

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/035/НА- СТА-ОНТС

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2026

2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 854,203,228.32 | 751,761,700.27 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 854,203,228.32 | 751,761,700.27 |
| 3121 | Төгрөг | 854,203,228.32 | 751,761,700.27 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 854,203,228.32 | 751,761,700.27 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 00.00 | 931,692,439.40 |
| 354 | Хангамжийн материал | 00.00 | 931,692,439.40 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 931,692,439.40 |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 854,203,228.32 | 1,683,454,139.67 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 854,203,228.32 | 1,683,454,139.67 |
| 413 | Өглөг | 183,357,788.00 | 14,000,000.00 |
| 4136 | Бусад өглөг | 183,357,788.00 | 14,000,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 183,357,788.00 | 14,000,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 183,357,788.00 | 14,000,000.00 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 183,357,788.00 | 14,000,000.00 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 670,845,440.32 | 1,669,454,139.67 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 670,845,440.32 | 1,669,454,139.67 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 670,845,440.32 | 670,845,440.32 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 998,608,699.35 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 670,845,440.32 | 1,669,454,139.67 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 854,203,228.32 | 1,683,454,139.67 |

1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 73,000,000.00 | 83,472,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 73,000,000.00 | 83,472,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 73,000,000.00 | 83,472,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,701,141,300.00 | 1,395,811,950.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 00.00 | 54,128,150.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 54,128,150.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 957,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 53,171,150.00 |
| 122 | Тусламжийн орлого | 300,000,000.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 300,000,000.00 | 00.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 1,401,141,300.00 | 1,341,683,800.00 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 1,401,141,300.00 | 1,341,683,800.00 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,774,141,300.00 | 1,479,283,950.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 1,701,114,248.09 | 472,675,250.65 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,701,114,248.09 | 480,675,250.65 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,701,114,248.09 | 480,675,250.65 |
| 220001 | Барилга байгууламж | 1,701,114,248.09 | 00.00 |

| | | | |
|------------|---|-----------------------------|------------------------------|
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 480,675,250.65 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,701,114,248.09 | 480,675,250.65 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>73,027,051.91</u> | <u>998,608,699.35</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 34,989,182.00 | 00.00 |
| 225002 | Найдваргүй авлагын алдагдал | 34,989,182.00 | 00.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 34,989,182.00 | 00.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -34,989,182.00 | 00.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>38,037,869.91</u> | <u>998,608,699.35</u> |

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|---------------------------------|---------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 73,000,000.00 | 83,472,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 73,000,000.00 | 83,472,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 73,000,000.00 | 83,472,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,703,141,300.00 | 1,395,811,950.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,000,000.00 | 54,128,150.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,000,000.00 | 54,128,150.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 957,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | 53,171,150.00 |
| 122 | Тусламжийн орлого | 300,000,000.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 300,000,000.00 | 00.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 1,401,141,300.00 | 1,341,683,800.00 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 1,401,141,300.00 | 1,341,683,800.00 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>1,776,141,300.00</u> | <u>1,479,283,950.00</u> |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>1,776,141,300.00</u> | <u>1,479,283,950.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 1,517,756,460.09 | 1,581,725,478.05 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,517,756,460.09 | 1,581,725,478.05 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,517,756,460.09 | 1,581,725,478.05 |
| 220001 | Барилга байгууламж | 1,517,756,460.09 | 00.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 1,581,725,478.05 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 1,517,756,460.09 | 1,581,725,478.05 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-1,517,756,460.09</u> | <u>-1,581,725,478.05</u> |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>00.00</u> | <u>00.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 258,384,839.91 | -102,441,528.05 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 595,818,388.41 | 854,203,228.32 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 854,203,228.32 | 751,761,700.27 |

1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Нийт дүн |
|---------------------------------------|-------------------|------------------|
| 2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 632,807,570.41 | 632,807,570.41 |
| Залруулсан үлдэгдэл | 632,807,570.41 | 632,807,570.41 |
| Тайлант үеийн үр дүн | 38,037,869.91 | 38,037,869.91 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 670,845,440.32 | 670,845,440.32 |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 670,845,440.32 | 670,845,440.32 |
| Залруулсан үлдэгдэл | 670,845,440.32 | 670,845,440.32 |
| Тайлант үеийн үр дүн | 998,608,699.35 | 998,608,699.35 |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,669,454,139.67 | 1,669,454,139.67 |

1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|-------------------------|-------------------------|------------------|--------|
| ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,451,278,600.00 | 1,479,283,950.00 | (28,005,350.00) | 101.93 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,451,278,600.00 | 1,425,155,800.00 | 26,122,800.00 | 98.20 |
| Орон нутгийн төсвөөс | 88,472,000.00 | 93,472,000.00 | 5,000,000.00 | 94.35 |
| Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 1,362,806,600.00 | 1,341,683,800.00 | 21,122,800.00 | 98.45 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | | 54,128,150.00 | (54,128,150.00) | |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 957,000.00 | (957,000.00) | |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 53,171,150.00 | (53,171,150.00) | |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,451,278,600.00 | 1,533,412,100.00 | (82,133,500.00) | 105.66 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,305,481,828.32 | 1,581,725,476.05 | 723,756,350.27 | 68.61 |
| Дотоод эх үүсвэрээр | 2,305,481,828.32 | 1,581,725,476.05 | 723,756,350.27 | 68.61 |
| Бусад хөрөнгө | 2,305,481,828.32 | 1,581,725,476.05 | 723,756,350.27 | 68.61 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 2,305,481,828.32 | 1,581,725,476.05 | 723,756,350.27 | 68.61 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 854,203,228.32 | 854,203,228.32 | - | 100.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 751,761,700.27 | (751,761,700.27) | |

2. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 85,081,556 (Наян таван сая наян нэгэн мянга таван зуун тавин зургаан) төгрөгөөр санхүүжүүлсэн "Ган утас мөнх" ХХК-ийн гүйцэтгэсэн "Баян-Өндөр сумын 0.4кВ-ын шугамын өргөтгөл, засварын шинэчлэл"-ийн ажлыг гүйцэтгэхдээ газрын зөвшөөрлийг аваагүй, айлын хашаанаас холбогдох журам, стандартад заасан хэмжээнд бариагүй зөрчил өмнөх онд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитаар илэрснийг зөрчлийг бүрэн арилгаагүй байгаа асуудлыг Баян-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд авч үзэх нь зүйтэй байна.

Мөн завсрын аудитаар илэрсэн тендер зарлах эрх бүхий хүн олдоогүй шалтгаанаар тендерийг 2025 оны 05 дугаар сараас хойш зарласан байгаа асуудлыг анхаарч, цаашид тендерийг эхний улиралд багтаан зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг дараагийн тайлант оны аудитаар хэрэгжилтийг үзэх шаардлагатай байна.

3. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 6,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 957.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 хариуцлага тооцох албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Завсрын аудитыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон 2025 оны 11 дүгээр сард гүйцэтгэж, аудитаар 174,904.4 мянган төгрөгийн илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайланд 14,907.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулан бүртгэлд тусган, ОНХС-ийн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 7,000.0 мянган төгрөгийн мэдээллийг нөхөн байршуулж, Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн оруулж, 13,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, актаар хүлээн авсан байна.

Завсрын аудитаар илэрсэн 140,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаанд өртэй аж ахуйн нэгж шалгаруулсан, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, зураг төсөв магадлалаар баталгаажаагүй байхад сумын ИТХ-аар баталсан зөрчилд зөвлөмж өгч, бусад асуудлыг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлөөр авч, зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

4. Ерөнхий чиглэлийн судалгааны талаар

ҮАГ-аас нэгдсэн журмаар авч байгаа ерөнхий чиглэлийн 8 судалгаанаас хамааралтай дараах 1 судалгааг гаргаж ажлын баримтад хавсаргав.

- Мэдээллийн технологийн зардлын тухайд: Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийг "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "ACOLOUS" программыг ашигладаг, тайлант жилийн хөгжүүлэлттэй холбоотой зардлыг сумын ЗДТГ-ын төсвөөс төлдөг байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,000.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

Залруулсан алдаа:

Сумын ИТХ-аар баталсан "Иргэд, төрийн албан хаагчдын мэдлэг оролцоог нэмэгдүүлэх" төсөл арга хэмжээний хүрээнд "Баянхонгор сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд сургалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г "Сонор" иргэдийн оролцоотой хамтын хөгжил" НҮТББ-тай байгуулж, тус аж ахуйн нэгжээс тайлант онд сургалтыг зохион байгуулсан, гэрээний төлбөрийн 8,000.0 мянган төгрөгийг олгоогүй байхад санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн аудитын "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх" батламж мэдэгдэл болон УСНББОУС-19 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, НББОУС-37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, МНС-6617-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх стандартын заалтыг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 423,593.5 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага өглөө.

5.1. Албан шаардлага

1. Баян-Өндөр сумын Засаг дарга, "Препер кран" ХХК-тай 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр сумын 4 дүгээр багийн төвийн өвлийн байрыг 289,593.5 мянган төгрөгөөр барих гэрээ байгуулж, ажлыг 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр ажлыг хүлээлгэн өгөхөөр заасан байхад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж хүлээлгэн өгөөгүй, гэрээнд заасан алдангийг гүйцэтгэгч аж ахуй нэгжээр төлүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Баян-Өндөр сумын Засаг дарга, "Препер кран" ХХК-ийн захирал нарын хооронд байгуулсан гэрээний 3-т "Гүйцэтгэгч нь Баян-Өндөр сумын 4 дүгээр багийн өвлийн байр барих ажлыг 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр эхэлж, 10 дугаар сарын 14-ний өдөр дуусгаж ашиглалтад оруулна /Стандартыг баримтална/, гэрээний 1.1 дэх тусгай нөхцөлийн "ГЕН 13.1-т заасан "Алданги ногдуулах хэмжээ хоног гэрээний үнийн 0.5 хувь байна" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: "Препер кран" ХХК-аар гэрээнд заасан алдангийг төлүүлж, 289,593.5 мянган төгрөгийн ажлыг чанартай бүрэн хийлгүүлж, мэргэжлийн байгууллагын хяналтыг хэрэгжүүлэн хүлээн авах, заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

2. Баян-Өндөр сумын ИТХ-ын тогтоолоор сумын төвийн гэрэлтүүлэг нэмэх сэргээн засах, 0,4 кв трансматор буулгах 120,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг зураг төсөвгүй баталж, "Elecbee" ХХК-ийн гүйцэтгэсэн зураг төсвөөр тендер зарлаж 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр "Гарьдсистемс" ХХК-тай 109,066.3 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь "Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна. барилга байгууламжийн хувьд барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх", Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь "Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ", 27 дугаар зүйлийн 27.3.2 дахь "Дараах үндэслэлээр барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзана: зураг төсөлд магадлал хийгдээгүй", 37 дугаар зүйлийн 37.1.10 дахь "Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, холбогдох зардлыг хариуцах", 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх "Барилгын ажил гүйцэтгэгч дараах чиг үүрэгтэй: барилгын ажлын зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: "Elecbee" ХХК-ийн гүйцэтгэсэн зураг төсвийг магадлалаар баталгаажуулж, баталгаажсан зураг төсвийн дагуу 109,066.3 мянган төгрөгийн ажлыг

"Гарьдсистемс" ХХК-аар чанартай бүрэн хийлгүүлж, заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

3. Сумын Засаг дарга "Баян-Өсөх агро" ОНӨААТҮГ-тай 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр сумын нутаг дэвсгэрийн 13 га талбайд хөрс боловсруулалт хийж бууцаар бордож, овъёосны үрээ хариуцан тарьж, намар хурааж өгөх ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэх 20,000.0 мянган төгрөгийн ажлын гэрээг 2025 оны 10 дугаар 01-ний өдрийн дотор хүлээлгэн өгөхөөр байгуулж, тус ажлын санхүүжилтэд гэрээний үнийн дүнгийн 70 хувь болох 14,000.0 мянган төгрөгийг олгосон атлаа ажлыг хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Баян-Өндөр сумын Засаг дарга, "Баян-Өсөх агро" ОНӨААТҮГ-ын гүйцэтгэгч захирал нарын хооронд байгуулсан гэрээний 2.1-т "Энэхүү гэрээ нь 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 01-ний хооронд хийж гүйцэтгэнэ", гэрээний 3.5-т "Ажил гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ зөрчиж ноцтой алдаа, дутагдал гаргасан болон хугацаа алдсан тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээг нэг талын санаачилгаар цуцлах ба өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй", гэрээний 4.3-т "Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: "Баян-Өсөх агро" ОНӨААТҮГ -аар гэрээнд заасан 14,000.0 мянган төгрөгийн ажлыг чанартай бүрэн хийлгүүлж, хүлээн авах, заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан албан тушаалтнуудад талархал илэрхийлье.

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|------------|-----------------|-----------------------------------|-----------------|--------------------------|----------|------------|-----------------|--------------|----------|----------|----------|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сумын ОНХС-ийн хөрөнгөөр сургалт хийх гэрээг Д.Болдбаатартай байгуулж, 2025 онд сургалтыг зохион байгуулсан байхад гэрээний төлбөрийн 8,000.0 мянган төгрөгийг төлөөгүй байхад санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна. | 1 | 8,000.0 | 1 | 8,000.0 | | | 1 | 8,000.0 | | | | |
| ДҮН | 1 | 8,000.00 | 1 | 8,000.00 | 0 | - | 1 | 8,000.00 | 0 | 0 | 0 | 0 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|--|-------------|-----------|---------------|----------|-----------------|-----------|----------|----------|--------------------------------------|---------------------|---|-----------|
| | | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Баян-Өндөр сумын Засаг дарга, "Препер кран" ХХК-тай 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр сумын 4 дүгээр багийн өвлийн байрыг 289,593.5 мянган төгрөгөөр барих гэрээ байгуулж, ажлыг 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр ажлыг хүлээлгэн өгөхөөр заасан байхад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж хүлээлгэн өгөөгүй, гэрээнд заасан алданийг гүйцэтгэгч аж ахуй нэгжээр төлүүлээгүй байна. | 1 | 289,593.5 | | | 1 | 289,593.5 | | | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|-----------|---|---|---|-----------|---|---|---|---|---|---|---|
| <p>Баян-Өндөр сумын ИТХ-ын тогтоолоор сумын төвийн гэрэлтүүлэг нэмэх сэргээн засах, 0,4 кв трансматор буулгах 120,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг зураг төсөвгүй баталж, "Elecbee" ХХК-ийн гүйцэтгэсэн зураг төсвөөр тендер зарлаж, 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр "Гарьдсистемс" ХХК-тай 109,066.3 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлыг хийж гүйцэтгэсэн байна.</p> | 1 | 109,066.3 | | | 1 | 109,066.3 | | | | | | | |
| <p>"Баян-Өсөх агро" ОНӨААТҮГ-тай 2025.06.16-ны өдөр 13 га талбайд хөрс боловсруулалт хийж бууцаар бордож, овьёосны үрээ хариуцан тарьж, намар хурааж өгөх ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэхээр 20,000.0 мянган төгрөгийн гэрээг сумын Засаг даргатай байгуулж, 2025.10.01-ний дотор хүлээлгэн өгөхөөр заасан, тус ажлын санхүүжилтэд 70 хувь болох 14,000.0 мянган төгрөгийг авсан атлаа ажлыг хүлээлгэн өгөөгүй байна.</p> | 1 | 14,000.0 | | | 1 | 14,000.0 | | | | | | | |
| Дүн | 3 | 412,659.8 | 0 | 0 | 3 | 412,659.8 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-------------------------|-------------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | | | | | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | 1 | | 1 | | | | | |
| | НИЙТ | 1 | | 1 | | | | | |

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 152/1/А0560252/БНА
2026/0357/АА -СТД -ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баян-Өндөр сумын Засаг дарга, “Препер кран” ХХК-тай 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр сумын 4 дүгээр багийн төвийн өвлийн байрыг 289,593,501 (Хоёр зуун наян есөн сая таван зуун ерэн гурван мянга таван зуун нэг) төгрөгөөр барих гэрээ байгуулж, ажлыг 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр ажлыг хүлээлгэн өгөхөөр заасан байхад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж хүлээлгэн өгөөгүй, гэрээнд заасан алдангийг гүйцэтгэгч аж ахуй нэгжээр төлүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Баян-Өндөр сумын Засаг дарга, “Препер кран” ХХК-ийн захирал нарын хооронд байгуулсан гэрээний 3-т “Гүйцэтгэгч нь Баян-Өндөр сумын 4 дүгээр багийн өвлийн байр барих ажлыг 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр эхэлж, 10 дугаар сарын 14-ний өдөр дуусгаж ашиглалтад оруулна /Стандартыг баримтална/, гэрээний 1.1 дэх тусгай нөхцөлийн “ГЕН 13.1-т заасан “Алданги ногдуулах хэмжээ хоног гэрээний үнийн 0.5 хувь байна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох,

6426090450

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. “Препер кран” ХХК-аар гэрээнд заасан алдангийг төлүүлж, 289,593,501 (Хоёр зуун наян есөн сая таван зуун ерэн гурван мянга таван зуун нэг) төгрөгийн ажлыг чанартай бүрэн хийлгүүлж, мэргэжлийн байгууллагын хяналтыг хэрэгжүүлэн хүлээн авах, заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шийдвэрийн хэрэгжилтийг гүйцэтгэл нийцлийн системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг дарга Д.Баяраа, нягтлан бодогч Ж.Долоон-Од нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

 Б.ДОЛЖМАА

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 133/2/АОБЕОЭ 58/БНА
2026/035/НА - СТА - ТУУЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Баян-Өсөх агро" ОНӨААТҮГ 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр сумын нутаг дэвсгэрийн 13 га талбайд хөрс боловсруулалт хийж бууцаар бордож, овъёосны үрээ хариуцан тарьж, намар хурааж өгөх ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэхээр 20,000,000 (Хорин сая) төгрөгийн гэрээг сумын Засаг даргатай байгуулж, 2025 оны 10 дугаар 01-ний өдрийн дотор хүлээлгэн өгөхөөр зааж, тус ажлын санхүүжилтэд гэрээний үнийн дүнгийн 70 хувь болох 14,000,000 (Арван дөрвөн сая) төгрөгийг авсан атлаа ажлыг хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Баян-Өндөр сумын Засаг дарга, "Баян-Өсөх агро" ОНӨААТҮГ-ын гүйцэтгэгч захирал нарын хооронд байгуулсан гэрээний 2.1-т "Энэхүү гэрээ нь 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 01-ний хооронд хийж гүйцэтгэнэ", гэрээний 3.5-т "Ажил гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ зөрчиж ноцтой алдаа, дутагдал гаргасан болон хугацаа алдсан тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээг нэг талын санаачилгаар цуцлах ба өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй", гэрээний 4.3-т "Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг: Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй" гэснийг зөрчсөн байна.

6426090452

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. “Баян-Өсөх агро” ОНӨААТҮГ -аар гэрээнд заасан 14,000,000 (Арван дөрвөн сая) төгрөгийн ажлыг чанартай бүрэн хийлгүүлж, хүлээн авах, заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шийдвэрийн хэрэгжилтийг гүйцэтгэл нийцлийн системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг дарга Д.Баяраа, нягтлан бодогч Ж.Долоон-Од нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

 Б.ДОЛЖМАА



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 154/3/АДТБ0238/БНА
2026/035/НА - СТА -ТМЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баян-Өндөр сумын ИТХ-ын тогтоолоор сумын төвийн гэрэлтүүлэг нэмэх сэргээн засах, 0,4 кв трансматор буулгах 120,000,000 (Нэг зуун хорин сая) төгрөгийн төсөл арга хэмжээг зураг төсөвгүй баталж, "Elecbee" ХХК-ийн гүйцэтгэсэн зураг төсвөөр тендер зарлаж, 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр "Гарьдсистемс" ХХК-тай 109,066,314 (Нэг зуун есөн мянга жаран зургаан мянга гурван зуун арван дөрөв) төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь "Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна. барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх", Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь "Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ", 27 дугаар зүйлийн 27.3.2 дахь "Дараах үндэслэлээр барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзана: зураг төсөлд магадлал хийгдээгүй", 37 дугаар зүйлийн 37.1.10 дахь "Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: барилга

6426090456

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, холбогдох зардлыг хариуцах”, 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх “Барилгын ажил гүйцэтгэгч дараах чиг үүрэгтэй: барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. “Elecbee” ХХК-ийн гүйцэтгэсэн зураг төсвийг магадлалаар баталгаажуулж, баталгаажсан зураг төсвийн дагуу 109,066,314 (Нэг зуун есөн мянга жаран зургаан мянга гурван зуун арван дөрөв) төгрөгийн ажлыг “Гарьдсистемс” ХХК-аар чанартай бүрэн хийлгүүлж, заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шийдвэрийн хэрэгжилтийг гүйцэтгэл нийцлийн системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг дарга Д.Баяраа, нягтлан бодогч Ж.Долоон-Од нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно